



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 12 сарын 29 өдөр

Дугаар А/451

Сүхбаатар

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Үйлчлүүлэгчдээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар санал асуулга авах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг нийт төр, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарт, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БҮРЭНБАТ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2013 оны
12 сарын 29-ний өдрийн 4/15 дугаар
захирамжийн хавсралт

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ХААГЧДЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР САНАЛ
АСУУЛГА АВАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл:

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам бусад хууль тогтоомжинд нийцүүлэн "Олон нийтийн оролцоо-төрийн үйлчилгээ" аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2008 стандартыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр.Зорилго:

Төрийн албан хаагчдын албан тушаалын чиг үүргийн хэрэгжилтэнд үйлчлүүлэгчдийн өгсөн санал асуулгыг тэдгээрийн үйл ажиллагааны мэргэшлийн түвшинг үнэлгээнд тусгах харилцааг зохицуулахад оршино.

Гурав.Журмын үйлчлэх хүрээ:

3.1.Энэхүү журмын үйлчлэлд дараах байгууллага, түүний ажилтан, албан хаагчид хамаарна.

3.1.1.Аймаг, сумын Засаг дарга, түүний ажлын алба

3.1.2.Багийн Засаг дарга, тосгоны захирагч, түүний ажлын алба

3.1.3.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, алба

3.1.4.Боловсрол, соёл, эрүүл мэнд, спортын салбарын байгууллагууд

3.1.5 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

Дөрөв.Үйлчлүүлэгчдийн санал асуулгыг авах арга, хэлбэр:

4.1. Байгууллагууд үйл ажиллагааныхаа онцлогтой уялдуулан үйлчлүүлэгчдийн саналыг дараах арга, хэлбэрээр авч болно. Үүнд:

4.1.1. Ил тод байршуулсан саналын хайрцагаар авах.

4.1.2. Санал асуулгын хуудсаар авах.

4.1.3. Санал асуулгыг авах суурин болон хөдөлгөөнт нээлттэй утас ажиллуулах.

4.1.4.Цахим хэлбэрээр авах.

4.1.5. "Иргэний танхим"-аар үйлчлүүлэгчдийн санал асуулгыг авах.

4.1.6. Аймаг, сумын Засаг даргын болон салбарын дээд шатны байгууллагын нэрэмжит үзлэгийн үеэр санал авах

4.1.7."Ээлтэй үйлчилгээг иргэн танд" /Нээлттэй хаалганы өдөр/ арга хэмжээний үеэр авах

4.1.8. Орон нутгийн теле шууд нэвтрүүлэг, уулзалт, ярилцлагаар авах

4.1.9. Шаардлагатай тохиолдолд нэгдсэн журмаар тусгайлан бэлтгэж авах

Тав.Үйлчлүүлэгчдийн санал асуулгыг авах, нэгтгэх, үр дүнг тооцох, тайлагнах:

5.1. Төрийн албан хаагчдын болон төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой санал асуулгыг санал асуулгын хуудасны үлгэрчилсэн загварийг ашиглан авч болно.

5.2. Санал асуулгын хуудсаар үйлчлүүлэгчдийн санал асуулгыг тухайн байгууллагын иргэдийн санал, өргөдөл, гомдол болон олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн ажилтан болон ёс зүйн хороо, хөндлөнгийн судалгааны мэргэшсэн байгууллагууд, иргэдийн төлөөллийг оролцуулан зохион байгуулж болно.

5.3. Үйлчлүүлэгчдээс санал асуулгыг жилд 2-оос доошгүй удаа авч нэгтгэж үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

5.4.Байгууллага бүр санал асуулгын үр дүнг тухай бүр тооцож, тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулж тайлагнана.

5.5.Санал асуулгын жилийн эцсийн нэгдсэн дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс гаргаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, зөвлөмж гарган шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

Зургаа.Санал асуулгын мөрөөр авах арга хэмжээ:

6.1.Санал асуулгын мөрөөр авсан ажил үйлчилгээний үр дүнгийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.

6.2.Төрийн албан хаагчидтай холбоотой иргэдийн санал асуулгын дүнг гэрээний үүргийн хэрэгжилтийн үнэлгээнд харгалзах үзүүлэлт болгон оруулна.

Үзүүлэлт тооцох аргачлал:

Төрийн албан хаагчийн тухайн жилийн гэрээний үүргийн хэрэгжилтийн нийт үнэлгээг 5 хүртэлх хувиар нэмэх буюу бууруулж тооцно.

Долоо. Үр дүн:

7.1. Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангахад иргэдийн оролцоо нэмэгдэнэ.

7.2. Төрийн байгууллагын ажил үйлчилгээ, албан хаагчдын ёс зүй, ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжинд тулгуурлан үнэлдэг тогтолцоог бүрдүүлнэ.

_____ оОо _____

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ
АСУУЛГЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Нэг.Ерөнхий мэдээлэл:

Таны нас.....

Боловсрол.....

Хүйс.....

Хоёр.Асуулт:

1.Үйлчилгээ авсан төрийн байгууллагын нэр:

.....

2.Дараах хүснэгтийн асуулга бүрийн ард өөрийн үнэлгээг “+” тэмдэгээр өгнө үү.

Асуулгын агуулга		Үнэлгээ			
		Сайн	Дунд	Муу	Мэдэхгүй
Байгууллагын	Үйлчилгээ				
	Тохижилт, соёл, ажиллах орчин нөхцөл				
	Ил тод нээлттэй байдал				

3.Тухайн байгууллагын удирдлагад хандаж хэлэх таны санал:

.....
.....
.....

Идэвхтэй оролцсон танд баярлалаа.

Огноо.....

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ
АСУУЛГЫН ХУУДАСНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Нэг.Ерөнхий мэдээлэл:

Таны нас.....

Боловсрол.....

Хүйс.....

Хоёр.Асуулт:

1.Үйлчилгээ үзүүлсэн төрийн албан хаагчийн нэр, албан тушаал:

.....

2.Дараах хүснэгтийн асуулга бүрийн ард өөрийн үнэлгээг “+” тэмдэгээр өгнө үү.

Асуулгын агуулга		Үнэлгээ			
		Сайн	Дунд	Муу	Мэдэхгүй
Төрийн албан хаагчийн	Үйлчилгээ				
	Мэдлэг, Ур чадвар				
	Харилцаа, ёс зүй				

3.Хэрэв та “дунд” буюу “муу” гэж үнэлсэн бол тухайн төрийн албан хаагчтай холбоотой саналаа бичнэ үү:

.....
.....
.....

Идэвхтэй оролцсон танд баярлалаа.

Огноо.....